



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жаакин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.11.21 № 39

БОЛОВСРОЛЫН САЙД
П.НАРАНБАЯР ТАНАА

Боловсролын ерөнхий хуулийн
зарим заалтын хэрэгжилтийн талаар

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт "Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас бусад боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч дараах тусгай шаардлагыг хангасан байна:", 33.2.1- д "багш мэргэжлээр их, дээд сургууль төгссөн боловсролын удирдлага, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний чиглэлээр энэ хуулийн 27.1.2-т заасан мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, төгссөн байх;", 33.2.2-т "боловсролын сургалтын байгууллагад тасралтгүй 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагад багшаар зургаагаас доошгүй жил, тэнхимийн эрхлэгч, албаны дарга, сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйчээр дөрвөөс доошгүй жил ажилласан, мэргэжлийн тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх." гэсэн заалтыг оруулж өгсөн нь төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчид тавигдах үндсэн шалгуурыг маш нарийн заасан шаардлага болсон. Энэ дагуу Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.6-г үндэслэн аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нар харьяалах ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын албан тушаалын тодорхойлолтыг баталж, тэр тодорхойлолтын хүрээнд сул орон тооны сонгон шалгаруулалтыг явуулдаг.

Боловсролын ерөнхий хуулийн дээрх заалт хэрэгжиж эхэлснээс хойш аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нар сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын албан тушаалын тодорхойлолтыг Боловсролын яамнаас ирсэн чиглэлийн хүрээнд баталж гаргасан гэх нэрийн доор хуулинд тусгаагүй шаардлагыг оруулж ирж байгаа тухай гомдлууд ирсээр байх тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хувьд Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нь Боловсролын ерөнхий хуулийн 33.2.1-д заасны дагуу "багш мэргэжлээр их дээд сургууль төгссөн байх" цорын ганц үндсэн шаардлагыг заасаар байхад

- Боловсролын судлал /0111/, Нийгмийн ажил /092301/ мэргэжлүүдийг нэмж оруулж ирсэн нь хуульд нийцэж байгаа эсэх тайлбарыг;
2. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нь Боловсролын ерөнхий хуулийн 33.2.2-т заасны дагуу "боловсролын сургалтын байгууллагад тасралтгүй 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагад багшаар зургаагаас доошгүй жил, тэнхимийн эрхлэгч, албаны дарга, сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйчээр дөрвөөс доошгүй жил ажилласан, мэргэжлийн тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх." гэсэн тусгай шалгуурын хэсэгт "захирал" гэсэн албан тушаалыг нэмж оруулж ирсэн нь хуульд нийцэж байгаа эсэх тайлбарыг;
 3. Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-т "Энэ хуулийн 28.4, 28.5-д заасан албан тушаалд тавих тусгай шаардлага, 33.2-т заасан албан тушаалд тавих тусгай шаардлагыг хангаагүй иргэнийг томилохыг хориглоно." гэж заасан байх тул энэхүү асуултын 1, 2 дахь хэсэгт заасан хуулийн зөрчилтэй албан тушаалын тодорхойлолтыг баримтлан явуулсан захирал, эрхлэгч нарын сонгон шалгаруулалтыг цуцалж, хуульд нийцсэн албан тушаалын тодорхойлолтын дагуу дахин сонгон шалгаруулалт зохион байгуулах боломжтой эсэх дүгнэлтийг;
 4. Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.5-д "Энэ хуулийн 33.2-т заасан шаардлагыг энэ хуулийн 17.1 дэх хэсэг, 25, 28 дугаар зүйлд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцож болох бөгөөд дүйцүүлэн тооцох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж заасны дагуу холбогдох журмыг боловсруулж гаргасан эсэх тайлбар зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ц.МӨНХТУЯА